



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 249

Улаанбаатар хот

“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус
гишүүн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшиүүлэх түр хорооноос ирүүлсэн дүгнэлт, Авлигатай тэмцэх газрын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 05/9420 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг тус тус харгалзан компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Хуягтын Батболдыг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг судалж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хараат бус гишүүнд, мэдүүлгийг хуульд заасан хугацаанд гаргуулан авахыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА
ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132830890
11-r-huraldaaan.docx